



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/311

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймаг дахь Төрийн аудитын газрын 2016 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 134/01 дугаар акт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөл бөмбөгийн холбоо, Хөгжлийн бэршээлтэй иргэдийн аймгийн зөвлөл, Мөнгөн цагираг клуб, Үйлдвэрлэлийн хоршоодын холбоонд олгосон дэмжлэг болох нийт 8,813,600 (найман сая найман зуун арван гурван мянга зургаан зуу) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлсүгэй.

2. Шаардагдах 8,813,600 (найман сая найман зуун арван гурван мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР